



# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/234

Булган

## Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг спортын их наадамд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх үйл ажиллагаанд зарцуулах 3 500 000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА *З.Бат* З.БАТЗОРИГ

